



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 27 өдөр

Дугаар A/38

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх
тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.9, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Гишүүнчлэлийн журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1.2.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Санхүүгийн зохицуулах хорооноос "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК-ийн үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тул үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.
2. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т тус тус даалгасугай.
3. Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсэн компанийн талаарх холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК-д тус тус мэдэгдсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБАТ

1526030076